

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭХ
АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.07.05

№12

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1.	Хүндэт иргэн цол олгох тухай	А.Амарзаяа	З.Мягмаржав	Тогтоол 45
2.	Хуралдааны тов тогтоох тухай	М.Дашпунцаг	З.Мягмаржав	Тогтоол 46

**ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
АЖЛЫН АЛБА**



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 45

Есөнбулаг сум

Хүндэт иргэн цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Шагналын журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмэр оруулсан Цэдэвийн Баянмөнхийг аймгийн “Хүндэт иргэн” цол, тэмдэгээр шагнасугай.
2. Аймгийн “Хүндэт иргэн” тэмдэг, дагалдах мөнгөн шагнал 500000 /таван зуун мянга/ төгрөгийг аймгийн төсвөөс гаргахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.

ДАРГА.  В.БАТЖАРГАЛ





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 46

Есөнбулаг сум

Хуралдааны тов өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын есдүгээр хуралдааныг 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдөр Алтай хотод хуралдуулахаар товыг өөрчлөн тогтоосугай.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, хуралдааны тов өөрчлөгдсөн талаар Төлөөлөгчдөд мэдээлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Амарзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА *А.Батжаргал* А.БАТЖАРГАЛ



0000153